



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/152

Хужирт сум

Түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (а), (ж), Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1, 69.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль явагдахтай холбогдуулан 2020 оны 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг, 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах болон хүнс, барааны дэлгүүрүүдийг ажиллахыг түр хориглосугай.

2. Дээрх захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Оюунгэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/153

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 6/4/01 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангаас малжуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2012 оны малжуулах төсөлд хамрагдан зээлээ бүрэн төлөөгүй, зээлийн хугацаа хэтэрсэн малчдын зээлийн эргэн төлөлтийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2. Эргэн төлөлтийг төвлөрүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж 2020 оны 11 дүгээр сарын 15-ны дотор бүрэн төвлөрүүлж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч (3.Цэцэгмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/154

Хужирт сум

Харгалзан дэмжигчээр тогтоох тухай

Гэр бүлийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шивээт 4 дүгээр багийн иргэн Энхбаатарын Нинжиймаа (ИС05261005) охины харгалзан дэмжигчээр түүний төрсөн эгч тус сумын Шивээт 4 дүгээр багийн иргэн Энхбаатарын Цэрэннадмидийг (ИС84012803) тогтоосугай.
2. Харгалзан дэмжих үүрэгт хяналт тавьж ажиллахыг 4 дүгээр багийн Засаг дарга (Д.Батбаяр) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/155

Хужирт сум

Дурсгалын зүйл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын нэр бүхий хоёр албан хаагчид 240000 (хоёр зуун дөчин мянга) төгрөгийн дурсгалын зүйлийг хавсралтаар олгосугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/156

Хужирт сум

Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл
сунгах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" 07/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд тамхины худалдаа эрхэлж буй Д.Долгорсүрэнгийн (ИС66021200) "Дулаан хайрхан" хүнсний дэлгүүрийн тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасугай.

2. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Хүнс, жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн (Б.Доржсэмбэ) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100311



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/157

Хужирт сум

Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах туай хуулийн 3 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 159 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 159 дүгээр тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан сумын хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/124 дүгээр захирамжийн 1 дүгээр заалтын “10 дугаар сарын 31-ний” гэснийг “12 дугаар сарын 31-ний” гэж өөрчилсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/158

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн барилгын хөгжлийн төвийн ажлын хэсэг сумын цэвэр усны нэгдсэн системийн зураг төсөв хийх ажлаар ирж ажилласантай холбогдуулан хоолны зардалд 275000 (хоёр зуун далан таван мянга) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 20²⁰ оны 11 дугаар
сарын 02 -ны өдрийн
А/158 дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын төрөл	Нэгжийн тоо	Нэгж ноогдох мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
Өглөөний хоол				
1	Банштай шөл	17	6500	110500
2	Гурилтай шөл	5	6500	32500
3	Цай	2	6000	12000
Оройн хоол				
4	Гурилтай шөл	17	6500	110500
5	Цай	1	9500	9500
				275000

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/159

Хужирт сум

Үнэлгээний хороо шинэчлэн байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Цагдаагийн тасагт автомашин нийлүүлэх ӨВАХУСЗДТГ/20200123" тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: З.Цэцэгмаа - Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Б.Ичинхоролцэвэлмаа - Мал аж ахуйн тасгийн дарга

Гишүүд: Б.Пүрэвжав - Төрийн сангийн мэргэжилтэн
Э.Нямдорж - Багш
Ж.Шижээ - Иргэний төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/160

Хужирт сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын “Газар өмчлүүлэх тухай” 2006 оны 25 дугаар захирамжийн хавсралтын 47, 2006 оны 60 дугаар захирамжийн хавсралтын 75 дугаарт байгаа 2 өрхийн нэр бүхий 8 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Хужирт сумын Засаг даргын 2020 оны
 11 дугаар сарын 20 - ны өдрийн 160 дугаар
 захирамжийн хавсралт

Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

Д/д	Өмчлөгчийн						Газрын				
	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Оршин суугаа хаяг	Регистр	16 нас хүрээгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар	Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо	Байршил	Хэмжээ /м2/	Газрын үнэ /Мян.төг/	
A	0	1	2	3	4	5	6	7	8	10	
47	1	Гэлэн	Мягмаржав	Жанчив	3-р баг	ЙС77111706		2006.03.16	5-р баг	5000	16740
	2	Саманд	Чулуунбаатар	Бямбахишиг	3-р баг	ЙС00250635		25			
140	3	Равжир	Сүх	Бат-Ойдов	УБ	ЙС66051020		2006.06.09	4-р баг	750	2360
	4	Халхаан	Банди	Төмөрбат	УБ	ЙС84090511		60			
	5	Халхаан	Банди	Пүрэвсүрэн	УБ	ЙС91011011					
	6	Халхаан	Банди	Баасанхүү	УБ	ЙС88070130					



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/161

Хужирт сум

Коронавируст (COVID-19) цар тахлын
халдвараас урьдчилан сэргийлэх
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн (а), Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны “Коронавируст (COVID-19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/500 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (COVID-19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл түр зогсоосугай.

2. Дээрх хугацаанд олон нийтийг хамарсан соёл, урлаг, спортын тэмцээн уралдаан, хурал цуглаан, Шашны байгууллагын үйл ажиллагаа, архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх, караоке, баар, цэнгээний газруудын үйл ажиллагааг түр хориглосугай.

3. Онцгой комиссын Шуурхай штабын жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

4. Сумын Онцгой комиссын 97190300 дугаарын утсанд цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг тухай бүрт өгч ажиллах, Аж ахуйн нэгж, байгууллага, худалдааны газруудад “Маскаа зүүцгээе-Гараа угаая” 2 дахь аяны хэрэгжилтийг хангуулж ариутгал, халдваргүйтгэлийг эрчимжүүлж ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (З.Цэцэгмаа), Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа (Х.Түмэнбаяр) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

250100321

Сумын Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 11 - ний өдрийн 116/дүгээр захирамжийн хавсралт



ШУУРХАЙ ШТАБЫН ГИШҮҮДИЙН
ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

№	Штабын гишүүдийн нэр	Албан тушаал	Хуваарь хийх он.сар.өдөр	Утасны дугаар
1	З.Цэцэгмаа	Засаг даргын Тамгын газрын дарга	2020.11.11 09.00-18.00	91010016
	Д.Дамдинтогтох	Холбооны эрхлэгч	2020.11.11	99661468
	Т.Элбэгсайхан	Архив, бичиг хэргийн эрхлэгч	18.00- 24.00	89126261
	Д.Мөнхбат	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн	2020.11.12 00.00- 09.00	88041391
	Б.Доржсэмбэ	ХЖДҮХХМэргэжилтэн		89500300
2	Д.Галиндэв	3 дугаар багийн Засаг дарга	2020.11.12	99946921
	Д.Уранчимэг	Санхүүгийн албаны дарга	09.00-18.00	80010404
	Д.Батбаяр	4 дүгээр Багийн Засаг дарга	2020.11.12	88115524
	Л.Цэдэв	ХЭЗХМэргэжилтэн	18.00- 24.00	99881077
	А.Гантулга	ЕБС-ийн захирал	2020.11.13	99032572
	С.Самдан	Мал, аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн	00.00-09.00	89545077
3	Ж.Мандах	Эрчим хүчний станцын техникч	2020.11.13	99068016
	Д.Норов	3 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч	09.00-18.00	88872744
	Ц.Амгалан	6 дугаар багийн Засаг дарга	2020.11.13	99609053
	Г.Оюунмандах	Нягтлан бодогч	18.00- 24.00	80010077
	Ц.Ундрахбаяр	Эрүүл мэндийн төвийн эрхлэгч	2020.11.14	89159619
	Б.Бямбасүрэн	Байгаль орчны хяналтын Улсын байцаагч	00.00- 09.00	92066129
4	З.Оюунчимэг	1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч	2020.11.14	90112272
	Ш.Эрдэнэхорол	2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч	09.00- 18.00	91091355
	Ц.Тунгалаг	Цаг уурын станцын эрхлэгч	2020.11.14	99278470
	Ц. Нямдорж	Газрын даамал	18.00- 24.00	92060200



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/162

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (а) дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 49 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.6, 4.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ойн дагалт баялаг хуш модны самрыг бэлтгэх ажил, сумын төвийн айл өрхүүдийн түлшний модны хэрэгцээг хангах зорилгоор сумдаас ирж хяналт тавьж ажилласан ажлын хэсгийн хоол хүнсний зардалд нийт 676550 (зургаан зуун далан зургаан мянга таван зуун тавин) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.


2. Дээрх зардалд зарцуулагдах хөрөнгийг Байгаль хамгаалах сангаас зарцуулахыг санхүүгийн албаны дарга (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2020 оны 11 дүгээр
сарын 12-ны өдрийн 11/а
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	талх	ширхэг	6	1000	6000
2	хэрчсэн гурил	ширхэг	8	1000	8000
3	боорцог	уут	1	3400	3400
4	сахар	кг	1	2150	2150
5	чихэр	кг	1	9500	9500
6	төмс	кг	10	1500	15000
7	Гар чийдэн	ш	1	3500	3500
8	кофе	ш	50	300	15000
9	Шар сав	ш	2	5000	10000
10	Хэрчсэн гурил	ш	20	600	12000
11	нухаш	ш	10	1300	13000
12	хиам	ш	5	6500	32500
11	шпрот	ш	5	4000	20000
12	Гурил 1 кг	ш	3	1200	3600
13	Өгөөж еэвэн	ш	2	4000	8000
14	гоймон	ш	10	2000	20000
15	Алчуур 6 хос	ш	1	3500	3500
16	00-ын цаас	ш	4	750	3000
17	Барааны саван	ш	3	900	2700
18	1 толгой шүдэнз	ш	1	500	500
19	трио	ш	1	3000	3000
20	GP зай	ш	2	750	1500
21	хогны уут	ш	1	5000	5000
22	Ажлын бээлий	ш	5	300	1500
23	угаалтуур	ш	1	1900	1900
24	Бал	ш	5	300	1500
25	лууван	кг	2	2000	4000
26	байцаа	кг	6.6	1500	9900
27	сонгино	кг	3.5	1500	5250
28	давс	ш	1	1000	1000
29	будaa	кг	5	2500	12500
30	цай	ш	1	2600	2600
31	боорцог	кг	5	3200	16000
32	килька	ш	5	2000	10000
33	сайра	ш	10	3500	35000
34	Сүү	л	6	2500	15000
35	Лаа	ш	1	550	550
36	Мах	кг	35	6000	210000
37	Ааруул	Кг	5	20000	100000
38	Айраг	л	20	2450	49000
бүгд					676550



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/163

Хужирт сум

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн
байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын (б), Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2, Авто тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" А/502 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (COVID-19) цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06.00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06.00 цаг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн төв, эмийн сан, банк, эрчим хүч, хүнсний дэлгүүр, хүнсний худалдаа, үйлдвэр эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, уст цэг, шатахуун түгээх станцын үйл ажиллагаанаас бусад нийтийн тээвэр, боловсролын байгууллага, барааны зах, дэлгүүр, халуун ус, үзвэр үйлчилгээний байгууллага болон олон нийтийг хамарсан соёл, урлаг, спортын тэмцээн уралдаан, хурал цуглаан, сүм хийд, зочид буудал, караоке, баар, цэнгээний газруудын үйл ажиллагааг түр зогсоосугай.

3. Хүнсний худалдаа, үйлдвэр эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, уст цэгийн ажиллах цагийн хуваарийг 09.00-20.00 цаг хүртэл тогтоосугай.

4. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд үйлчлүүлж байгаа иргэд болон ажиллагсдын биеийн халууныг үзэж нэвтрүүлэх, гар ариутгах, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, цэвэрлэгээ, үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийн байдалд дотоодын хяналт тавьж ажилласугай

5. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06.00 цаг хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

6. Сумаас гарах, орох, сум дотор эрүүл мэндийн үйлчилгээ авах, буяны үйл ажиллагаа, хүнс, шатахууны тээврээс бусад бүх хөдөлгөөнийг хориглосугай.

7. Эрүүл мэндийн үйлчилгээ авах, хүнс цуглуулах, ундны усны хэрэгцээг хангахаас бусад тохиолдолд гэрээс гарахгүй байхыг нийт ард, иргэдэд уриалсугай.

8. Хөдөлгөөн хязгаарласантай холбогдуулан хяналтын 6 цэгт, хөдөлгөөнт 4 цэгт ажиллах албан хаагчдыг томилж ажилуулсугай.

9. Коронавируст (COVID-19) цар тахлын цаг үеийн нөхцөл байдлын талаар ард, иргэдэд үнэн зөв мэдээлэл өгч, зөвлөмж хүргүүлэн хүнсний бүтээгдэхүүн, эмийн хэрэгсэлийн үнийн хөөрөгдөлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг холбогдох байгууллагын албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлүүлж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн (Б.Доржсэмбэ)-д даалгасугай.

10. Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага болон Эрүүл мэндийн төвийн байгууллагаас бусад төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагууд 0-5 насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд дотоод журмын хүрээнд цалинтай чөлөө олгож, ажилтан, албан хаагчдыг цахимаар ажиллуулах нөхцөлөөр хангаж ажиллуулахыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

11. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (З.Цэцэгмаа), Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Х.Түмэнбаяр) нарт үүрэг болгосугай.

12. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Коронавируст (COVID-19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/161 дүгээр захирамжийн 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/164


Хужирт сум

Тандалт судалгаа хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а" Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2020 оны "Монгол улсыг үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлжүүлсэн болохыг баталгаажуулах тухай" А/118 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн хэрэгцээнд төхөөрч буй үхэр, ямаанд эмнэл зүйн болон эмгэг бүтцийн үзлэг шинжилгээг хийж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Тархвар зүйч эмч (Т.Сундуйбаяр)-д даалгасугай.
2. Эмнэл зүйн шинж тэмдэг болон эмгэг бүтцийн өөрчлөлттэй ямаа, үхрийг мал эмнэлгийн нэгж болон мал эмнэлгийн тасагт мэдээлж ажиллахыг малчид, иргэдэд үүрэг болгосугай.
3. Ямааны годрон, үхрийн цээж өвчний талаар сургалт сурталчилгаа явуулж, заавар зөвлөмж тарааж ажиллахыг Мал эмнэлгийн тасагт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100327



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/165

Хужирт сум

Гамшгаас хамгаалах бүх нийтийн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, “ж”, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2, Авто тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэнбайдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 181 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (COVID-19) цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасугай.

2. Сумаас орох, гарах, баг хоорондох эрүүл мэндийн үйлчилгээ авах, буяны үйл ажиллагаа, хүнс, мал мах, шатахуун, нүүрс тээврээс бусад бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл түр зогсоосугай.

3. Хүнсний худалдаа, үйлдвэр эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, уст цэгийн ажиллах цагийн хуваарийг 09:00-18:00 цаг хүртэл тогтоосугай.

4. Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд хориглосугай.

5. Төрийн байгууллагууд тусгай горимын дагуу ажиллаж, 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөлийг бүрдүүлсүгэй.

6. Сумын иргэд хөдөө явж идэш хоолоо бэлтгэхэд хөдөлгөөний эрчим нэмэгдэх учир, мал, мах, идэш авах хүмүүстэйгээ утсаар холбогдон 2020 оны 11 дүгээр сарын 17-нын өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд сум тойрсон хяналтын постон дээр авчруулж, хүлээлгэн өгөх зохицуулалт хийсүгэй.


250100329

7. Эрүүл мэндийн үйлчилгээ авах, хүнс цуглуулах, ундны усны хэрэгцээг хангахаас бусад тохиолдолд гэрээс гарахгүй байхыг нийт ард, иргэдэд уриалсугай.

8. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (З.Цэцэгмаа), Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Х.Түмэнбаяр) нарт үүрэг болгосугай.

9. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" А/163 дугаар захирамжийн 1,3,5 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/166

Хужирт сум

Коронавируст (COVID-19) халдварын үед
нэмэлтээр ор дэлгэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5, 10.4.4, 18 дугаар зүйлийн 18.4, 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эмнэлэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зураглал, батлах туай” А/101 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны “Коронавируст халдвар (COVID-19)-ын үед нэмэлтээр ор дэлгэх тухай” А/75 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед нэмэлтээр ор дэлгэх төлөвлөлтийг нэгдүгээр, голомтод ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны нэрсийн жагсаалтыг хоёрдугаар, хавьтагсдын тусгаарлах байр, ажиллах эмч, мэргэжилтнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нэмэлтээр ажиллах тасаг, нэгжийг бэлтгэн, дайчлан ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг сургаж дадлагажуулах, шаардлагатай эм, эмнэлэгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хоол хүнсний бэлэн байдлыг хангаж нөөцийг бүрдүүлэхийг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Ц.Ундрахбаяр), рашаан сувилалдуудын дарга нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны “Коронавируст халдвар (COVID-19)-ын үед нэмэлтээр ор дэлгэх тухай” А/50 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100331



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/167

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а" дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг нэгдүгээр, сумын Нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт нэгтгэх ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар байгуулсугай.

2. Дээрх бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, биелэлт нэгтгэн гаргах ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн дотор үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгүүдэд, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100341

Сумын Засаг даргын 20²⁰ оны 11.
дүгээр сарын 23 ны өдрийн 116 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн
төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: З.Цэцэгмаа - Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: Л.Цэдэв - Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн
Д.Уранчимэг - Санхүүгийн албаны дарга
Б.Ичинхоролцэвэлмаа - Мал эмнэлгийн тасгийн
дарга
Б.Бямбасүрэн - Байгаль орчны асуудал хариуцсан
Мэргэжилтэн
Д.Мөнхбат - Бэлчээр, газар тариалан хариуцсан
мэргэжилтэн
Ц.Нямдорж - Газрын даамал
С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан
мэргэжилтэн
Б.Доржсэмбэ - Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны
асуудал хариуцсан мэргэжилтэн

-оОо-

Сумын Засаг даргын 2020 оны 11.
дүгээр сарын 23 ны өдрийн 1167 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

Сумын Засаг даргын “Бүтээлч Хужирт-2020” мөрийн хөтөлбөр,
сумын Нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн
биелэлт нэгтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: З.Цэцэгмаа - Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: Л.Цэдэв - Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн
Д.Уранчимэг - Санхүүгийн албан дарга
Б.Ичинхоролцэвэлмаа - Мал эмнэлгийн тасгийн
дарга
Б.Бямбасүрэн - Байгаль орчны асуудал хариуцсан
Мэргэжилтэн
Д.Мөнхбат - Бэлчээр, газар тариалан хариуцсан
мэргэжилтэн
Ц.Нямдорж - Газрын даамал

-оОо-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 4/168

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Цаашид авах арга хэмжээний тухай” 19 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 14/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 5 дугаар багийн нутаг “Жем Хужирт” ХХК-ний өөрийн эзэмшлийн газартаа зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ногоон байгууламж болон барилга барьсан 0,6795 га газрыг суурь үнээр нь тус компанид үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.
3. Захирамж гарсанаас хойш 90 хоногийн дотор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүх археологийн судалгаа хийлгэхийг “Жем Хужирт” ХХК-ний захирал Г.Сэндмаад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/169

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар суманд баригдаж байгаа цэвэрлэх байгууламжийн ажлын явцад хяналт тавихаар Улаанбаатар хотоос ажлын хэсэг суманд ирж ажилласантай холбогдуулан хоолны зардалд 216500 (хоёр зуун арван зургаан мянга таван зуу) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/170

Хужирт сум


Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын харьяат Улсын начин Уртнасангийн Сүхбаатар нь өвчний улмаас нас барсан тул 300000 (гурван зуун мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/171

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг суманд ирж ажилласантай холбогдуулан хоолны зардалд 49200 (дөчин есөн мянга хоёр зуу) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2020 оны 11 дугаар
сарын 25-ны өдрийн
117 дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын төрөл	Нэгжийн тоо	Нэгж ноогдох мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
1	Банштай цай	4	8500	34000
2	Салат	4	3800	15200
				49200

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/172

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс ажлын хэсэг суманд ирж ажилласантай холбогдуулан хоолны зардалд 42500 (дөчин хоёр мянга таван зуу) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100343

Сумын Засаг даргын 20²⁰ оны 11 дугаар
сарын 25 -ны өдрийн
4/172 дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын төрөл	Нэгжийн тоо	Нэгж ноогдох мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
1	Үхэрийн шарсан мах	5	8000	8000
2	Цай	5	500	2500
				42500

-оОо-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/173

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас ажлын хэсэг суманд ирж ажилласантай холбогдуулан хоолны зардалд 118600 (нэг зуун арван найман мянга зургаан зуу) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 20²⁰ оны 11 дугаар
сарын 25 -ны өдрийн
4/173 дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын төрөл	Нэгжийн тоо	Нэгж ноогдох мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
1	Цуйван	2	13900	27800
2	Тойгны шөл	3	14100	42300
3	Сүүтэй цай	5	1500	7500
4	Тавгийн чихэр	1	12000	12000
5	Кофе	1	15000	15000
6	Кофе сүү	1	9500	9500
7	Ёотон	2	4500	9000
				118600

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/174

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын уугуул, Нутгийн зөвлөлийн дарга Чойгүнсэнгийн Чимэдсүрэн докторын (Ph.D) зэрэг хамгаалсантай холбогдуулан хүндэтгэл үзүүлэхэд 155000 (нэг зуун арван найман мянга зургаан зуу) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 20²⁰ оны 11 дугаар
сарын 25-ны өдрийн
А/НУ дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын төрөл	Нэгжийн тоо	Нэгж ноогдох мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
1	Зураг	1	120000	120000
2	Ааруул	1	35000	35000
				155000

-оОо-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/175

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг ажлын хэсгийн хамт суманд ирж ажилласантай холбогдуулан хоолны зардалд 159100 (нэг зуун тавин есөн мянга нэг зуу) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 20⁰⁰ оны 11 дугаар
сарын 25 -ны өдрийн
1/15 дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын төрөл	Нэгжийн тоо	Нэгж ноогдох мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
Өглөө				
1	Банштай цай	7	11000	77000
Орой				
2	Банштай ногоотой шөл	7	8500	59500
3	Мантуу	7	1500	10500
4	Цай	1	12100	12100
				159100

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/176

Хужирт сум

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Ерөнхий боловсролын сургуулийн захиралын албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, 1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, 3 дугаар Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр, 4 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын захирал, эрхлэгч нарын албан тушаалын тодорхойлолтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (ЗЦэцэгмаа)-д даалгасугай.

3. Албан тушаалын тодорхойлолтын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг байгууллагын захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/177

Хужирт сум

Газар ашиглах эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр баг Шивээт 48 тоот хаягт байрлах "ХААН банк" ХХК-ний 6211000269 нэгж талбарын дугаар бүхий банк санхүүгийн байгууллагын зориулалттай 500 м² газрын ашиглах эрхийн гэрчилгээг 5 жилийн хугацаатай сунгасугай.

2. Шинээр газар ашиглах гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100353



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/178

Хужирт сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" А/543 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06.00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 06.00 цаг хүртэл хугацаагаар сунгасугай.

2. Сумын хойд талын Шунхлай уулзварын байнгын хяналтын цэгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 06:00 цаг хүртэл ажиллуулсугай.

3. Халдвартай бүсээс ирсэн иргэдийг гэрийн хязгаарлалтад 14 хоног байх хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Эрэн хайх, аврах бүлгийн бүлгийн дарга, ажиллагааны зааварчлагч (Д.Баянсан), Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, хүнсний худалдааны газруудын ажиллах цагийн хуваарийг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 09.00-18:00 цаг, худалдаа үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудыг 10:00-17:00 цаг хүртэл ажиллуулсугай.

5. Сумын Онцгой комиссын Шуурхай штабын 24 цагийн жижүүрийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хуваарийн дагуу ажиллуулсугай.

6. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06.00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 06.00 цаг хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06.00 цаг хүртэлх хугацаанд хориглосугай.

7. Сүм хийд үйл ажиллагаа явуулахдаа иргэд, олон нийтээс цахимаар болон үүрэн телефоны утсаар захиалга, үйлчилгээний хүсэлтийг авч олон нийтийг цуглуулахгүйгээр, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин, дотоод үйл ажиллагаагаа (ном хурах) зохицуулж ажиллахыг чиглэл болгосугай.

8. Олон нийтийг хамарсан соёл, урлаг, спортын арга хэмжээ, хурал, жагсаал, цуглаан, караоке, баар, цэнгээний газруудын үйл ажиллагааг дээрх хугацаанд зохион байгуулахыг түр хориглосугай.

9. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд үйлчлүүлж байгаа иргэдийн биеийн халууныг хэмжиж, амны хаалт зүүсэн эсэхэд хяналт тавин, нэг удаагийн бэлий, гар ариутгагчаар хангаж үйлчилгээ үзүүлэх, байгууллагын орчны хяналтын камерын байнгын ажиллагааг хэвшүүлж, хяналтын камерын бичлэгийг 30 хоног хүртэл хадгалж архивлахыг үүрэг болгосугай.

10. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (З.Цэцэгмаа), Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Х.Түмэнбаяр) нарт үүрэг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/179

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

